

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсныг
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк болон “Ти Ди Би Лизинг” ХХК нарын хооронд 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй, №ЗЭНГ/СС250312022-3 дугаартай “Зээлийн эрх нээх гэрээ” болон №АБ/СС250312022-3 дугаартай “Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх гэрээ”, мөн №ЗБ/СС250312022-3-4 дугаартай “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ”-г тус тус хүлээн зөвшөөрч, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг удирдлага болгон хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОПША